

GrCF3 W2 - Зүрх судасны үндэсний төв төсөл

Байршил:	Монгол Улс
Төслийн дугаар:	55677
Бизнесийн салбар:	Хот суурин газар болон байгаль орчны дэд бүтэц
Мэдэгдлийн төрөл:	Төрийн
Байгаль орчны ангилал:	“В”
Батлагдах огноо:	2025 оны 6 дугаар сарын 11
Статус:	ТУЗ-ийн шийдвэр хүлээгдэж буй
Төслийн хураангуй англи эх гарсан:	2024 оны 10 дугаар сарын 24

Төслийн танилцуулга

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод Зүрх судасны үндэсний төв (ЗСҮТ)-ийн 120 ортой эрүүл мэндийн шинэ байгууламж барих ажлыг санхүүжүүлэхэд зориулсан 34.9 сая хүртэлх ам.долларын Засгийн газрын зээл. Уг төслийг Монгол улсын Эрүүл мэндийн яам Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэг (“ШУГТЭ”), ЗСҮТ-тэй хамтран хэрэгжүүлнэ.

Төслийн зорилго

Энэхүү төсөл нь Улаанбаатар хотыг Ногоон хот болгох үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хэрэгжиж буй хөрөнгө оруулалт бөгөөд хөтөлбөрийн нэг чиглэл болох барилгын эрчим хүчний хэмнэлтийг сайжруулах чиглэлийг дэмжих болно. Төслийн байгууламж нь нь ЕРС А+ гэрчилгээний шаардлага хангасан байх бөгөөд суурь үзүүлэлттэй харьцуулахад анхдагч эрчим хүчний хэмнэлт 22 хувь, усны хэмнэлт 38 хувь байх төлөвтэй байна. Төсөл нь Монгол улс дахь зүрх судасны өвчний нарийн төвөгтэй эмчилгээ, асаргааны чанар, хүртээмжийг сайжруулах хэрэгцээг хангахад чиглэж байна.

Шилжилтийн нөлөөлөл

Шилжилтийн хүлээгдэж буй нөлөөлөл (ETI)-ийн оноо: 70

Төслийн хүлээгдэж буй шилжилтийн нөлөөлөл нь шинэ эмнэлгийн барилгад дотоод орчин, эрчим хүч, усны хэрэглээг сайжруулах арга зүйг нэвтрүүлж, эрчим хүчний хэмнэлттэй хөрөнгө оруулалт хийх замаар "Ногоон" шилжилтэд төвлөрөх юм.. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох шийдлүүдийг зураг төсөлд тусгаж, 100 хувь Ногоон эдийн засгийн шилжилтийг дэмжинэ.

Тус төсөл нь Монгол улсад зүрх судасны эмнэлзүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, гадаад улсад эмчлүүлэх хэрэгцээг бууруулах, бүс нутгийн эрүүл мэндийн сүлжээг бэхжүүлэх зорилготой. Мөн алслагдсан бүс нутагт амьдарч буй иргэдийн зүрх судасны эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахын зэрэгцээ сургалт, телемедицинд тулгуурлан шилжилтийн Хүртээмжтэй чанарыг дэмжихэд чиглэнэ.

Харилцагчийн тухай мэдээлэл

МОНГОЛ УЛС

ЕСБХБ-ны санхүүжилтийн тойм

34,870,000.00 ам.доллар

Төслийн нийт өртөг

54,809,000.00 ам.доллар

Нэмэлт ашиг тус

- Санхүүжилтийн бүтэц: өөр эх үүсвэрээс санхүүжилт авах боломжгүй улсын эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн эрэлт хэрэгцээг нөхөх.
- Эрсдэлийг саармагжуулах: Нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг жилд 499 тонноор бууруулж, уур амьсгалын биет эрсдэлд тэсвэртэй байх чадвар бий болгосноор нүүрстөрөгчийн шилжилтийн эрсдэлийг саармагжуулах.
- Стандарт тогтоох: Монгол улсын ногоон барилгын схем мөрдөж байгаль орчны илүү өндөр стандартад хүрэх., мөн олон улсын худалдан авалтын шилдэг стандарт хэрэгжүүлэх, ШУГТЭ-т Тэгш Боломжийн Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах замаар жендерийн оролцоо, стандартыг дэмжих

Байгаль орчин, нийгмийн тойм

“В” ангилал. Төслийн байгаль орчин, нийгмийн магадлан шинжилгээг барилгын зөвшөөрөл авах зорилгоор боловсруулсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ) болон Банкны хараат бус зөвлөхийн бэлтгэсэн техникийн тайланг үндэслэн хийсэн болно. Төслийн хүрээнд баригдах байгууламж нь ШУГТЭ-ийн хажууд, орон сууц, худалдаа, оффисын зориулалттай барилгуудын дунд байрших бөгөөд ШУГТЭ-ийн эзэмшлийн газар дээр баригдана. Иймээс нэмэлт газар чөлөөлөлт шаардагдахгүй. Байгаль орчин, нийгмийн гол эрсдэл, асуудлууд нь төслийн байршил, зураг төсөл, барилгын үе шаттай холбоотой. Төслийн талбай нь Улаанбаатар хотын Баянгол дүүрэг нь хүн амын нягтаршил өндөртэй бүс бөгөөд ийм хэмжээний барилга байгууламж барихад түр зуурын орчны нөлөөлөл үүсч болзошгүй. Эдгээр нөлөөллийг барилгын менежментийн сайн туршлагаар удирдан зохицуулах боломжтой. Төслийн гүйцэтгэгч тал Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ)-г боловсруулж, энэхүү төлөвлөгөөнд хүрээлэн буй орчин, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, онцгой байдлын бэлэн байдал ба хариу арга хэмжээ, аюултай материалын менежмент, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, замын хөдөлгөөний зохицуулалт зэрэг асуудлыг тусгасан менежментийн төлөвлөгөөг багтаан хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнээс гадна байгаль орчны нөлөөллийн үндэсний үнэлгээний шаардлага, зөвлөмжийг БОНУАТ-д тусгах нь зүйтэй.

Судалгааны явцад төслийн талбайд гэр хэлбэрийн нэгэн байгууламж байгааг тогтоосон бөгөөд эзэмшигчтэй нь холбогдон, тус байгууламжийг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой шаардлагатай алхмуудыг харилцан тохиролцсон болно.

Шинэ эмнэлгийн барилга ашиглалтад орсны дараа олон улсын сайн туршлагад нийцсэн удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд үүнд чанарын удирдлагын ISO 9001, байгаль орчны менежментийн ISO 14001, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ISO 45001, мөн мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001 стандартууд багтана. БОНУАТ-нд Жендэрт суурилсан хүчирхийлэл, дарамттай тэмцэх бодлогыг боловсруулахболон галын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг олон улсын шилдэг жишгийн дагуу тусгаж, ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага 2 болон 4-т нийцүүлэх шаардлагатай.

Төслийг Банкны Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэхээс өмнө БОНУАТ-г харилцагч талтай бүрэн тохиролцсон байх шаардлагатай. Мөн харилцагч тал тухайн жилд БОНУАТ-ний хэрэгжилт болон гарсан байгаль орчин, нийгмийн асуудлын талаар жил бүр тайлан гаргаж, Банкинд хүргүүлэх үүрэгтэй.

Техник хамтын ажиллагаа (ТХА) ба буцалтгүй тусламжийн санхүүжилт

Гарын үсэг зурахын өмнөх:

ТХА 1: Төслийн техник болон эдийн засгийн үнэлгээ; Банкны хөрөнгөөр санхүүжих.

ТХА 2: Худалдан авалтын завсрын тусламж; Төслийн хэрэгжилтийг дэмжих зөвлөхүүд сонгож авахад туслах, олон улсын донор болон/эсвэл ХНТС-гаас санхүүжүүлнэ.

Гарын үсэг зурсны дараах:

ТХА 1: Төслийн хэрэгжилтэд үзүүлэх дэмжлэг; олон улсын донор болон/эсвэл ХНТС-гаас санхүүжүүлнэ.

Компанитай холбоо барих мэдээлэл

Я.Болормаа
bolormaa_ya@moh.gov.mn
976-51-263820
www.moh.gov.mn

Засгийн газрын VIII байр, Олимпийн гудамж – 2, Улаанбаатар 14210, Монгол Улс

Төслийн хураангуй сүүлд шинэчлэгдсэн:

2025 оны 5 дугаар сарын 5

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг [эндээс](#) авна уу.

Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168 Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл [ЕСБХБ-ны Худалдан авалт](#) хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794 Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

БОНБ болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх, мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн улмаас үүсэх эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг **БОНБ**-д оруулсан болно.

Бүрэн төгс байдал ба комплаенс

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Түүнчлэн, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл гадна байгаа хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг КЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алианаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#) хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн [Байгаль орчин, нийгмийн бодлого](#), эсвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#)-ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл [Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт](#), хянан шалгуулах хүсэлт тавих бол [Хүсэлт](#) хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол ipam@ebrd.com цахим шуудангаар хандаж болно.